

**“ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛЫН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН  
ӨНГӨРҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 08 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар нарын 31 гишүүн 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос уг тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулагдсаныг шинэчлэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбатаар ахлуулан гишүүдэд нь Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Б.Жавхлан, Б.Наранхүү, Н.Цэрэнбат нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед ажлын хэсгээс гаргасан тогтоолын төслийг бүхэлд нь өөрчлөн найруулах саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.


“Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**Н.ЭНХБОЛД**

**“ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛЫН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН  
ӨНГӨРҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХИ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН САНАЛ:**

1. Улсын Их Хурлын тогтоолын төслийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

**“Юмжаагийн Цэдэнбал агсны алдар гавьяаг мөнхжүүлж, түүний  
мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар  
авах зарим арга хэмжээний тухай**

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга асан, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын Маршал Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх, амьдрал, бүтээлийн талаархи түүхэн үнэнийг сурталчлан таниулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монголын Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Юмжаагийн Цэдэнбал агсны мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Юмжаагийн Цэдэнбал агсны амьдрал, үйл ажиллагааны талаархи түүхэн үнэнийг ард түмэнд сурталчилан таниулж алдар гавьяаг нь мөнхжүүлэх арга хэмжээ авах;

2/Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, зохион байгуулах комисс байгуулан ажиллуулах;

3/Юмжаагийн Цэдэнбал агсны музей байгуулах арга хэмжээ авч төрөөс түүнд болон эхнэрт нь олгосон шагнал, бэлэг дурсгал, эдэлж хэрэглэж байсан зүйлсийг уг музейд байрлуулах;

4/Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд судалж шийдвэрлэх.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд үүрэг болгосугай.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат,  
Д.Лүндээжанцан, Б.Жавхлан, Н.Цэрэнбат**